

# Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүний онцлох өөрчлөлтүүд



## Холбоо барих:

### Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
sergi.kobakhidze@pwc.com

### Чойжамцын Цэндмаа

Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
tsendmaa.choijamts@pwc.com

### Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

### Отгонтогтоолын Мөнхнасан

Ахлах хуульч  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
munkhnasan.otgontogtool@pwc.com

### Өмгөөллийн

### ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
Факс : +976 11 322068

[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)



## Хураангуй

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (“Шинэчилсэн найруулга”) хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 1-р сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тус хуулийн шинэчилсэн найруулга нь төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хүний оролцоог бууруулах, тендерийн шалгаруулалтыг шуурхай хялбар явуулах, хариуцлага, хяналтын тогтолцоог шинэчлэх зорилготой батлагдсан юм. Энэхүү татвар, хууль эрх зүйн мэдээллээрээ тус хуулийн онцлох өөрчлөлтүүдийг хүргэж байна.



## Онцлох өөрчлөлтүүд

### Худалдан авах ажиллагааг бүрэн цахим системээр гүйцэтгэнэ

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэхээр заасан. Энэ хүрээнд эрх бүхий байгууллагаас хөтөлж, бүрдүүлсэн мэдээллийн санд байгаа олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй байх зохицуулалт орсон.

Шинэчилсэн найруулгын дагуу цахим систем нь дараах дөрвөн төрлийн бүртгэлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулна. Үүнд:

- Захиалагч;
- Худалдан авах ажиллагаанд оролцох аж ахуй эрхлэгч;
- Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан; болон
- Бараа, ажил, үйлчилгээний каталог.

Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгүүлсэн этгээд нь өөрийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан талаарх мэдээлэл, баримт бичгийг оруулан өөрийн хувийн бүртгэлийг үүсгэх бөгөөд өөрийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орох бүрд шинэчлэх үүрэгтэй ба мэдээллийн үнэн зөвийг хариуцахаар хуульчилсан байна. Энэ нь тендерт оролцогчдын хувьд илүү хялбар бөгөөд цаг хугацаа, зардал хэмнэх боломжийг бүрдүүлсэн гэж харагдаж байна.

### Баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулна

Тендерт оролцогчид нь тендерийн саналыг тоон гарын үсгээр баталгаажуулж, цахим системээр илгээх замаар худалдан авах ажиллагаанд оролцоно. Харин гадаадын этгээд Монгол Улсад олгосон тоон гарын үсгийн гэрчилгээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу гадаад улсын тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглах боломжтой.

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.



## Онцлох өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

### Түншлэл болон туслан гүйцэтгэгч

Тендерт түншлэлээр оролцож буй тохиолдолд түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг тендерийн үнийн 20 хувиас дээш байх шаардлага тавигдана. Харин тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно.

### Гадаадын этгээд

Шинэчилсэн найруулгын дагуу “гадаадын этгээд” гэж гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд, гадаадын иргэн, эсхүл харьяалалгүй хүнийг хэлэхээр хуульчилсан. Гадаадын этгээд нь ажлын хувьд 30 тэрбум, барааны хувьд 1 тэрбум, үйлчилгээний хувьд 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцож болно.

### Илт хууль бус гэрээ

Шинэчилсэн найруулгаар гэрээ эсхүл тендер шалгаруулалтын дараах шийдвэрийг илт хууль бусад тооцох нөхцөлийг заасан. Үүнд, тус хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан, мөн тус хуулийг зөрчиж нэг эх үүсвэрээс худалдан авсан, тус хуульд зааснаар зарлал нийтлээгүй, эсхүл урилга хүргүүлээгүй, тус хуульд зааснаар тендертэй танилцах эрхийг хязгаарласан, тендер хүлээн авах эцсийн хугацааг, эсхүл тус хуульд заасан гэрээ байгуулах хугацааг баримтлаагүй, захиалагчийн тус хуульд заасан бусад зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн зэрэг нөхцөл байдал орно.



## Тендер шалгаруулалт

### Тендер шалгаруулалтын арга

Шинэчилсэн найруулгын дагуу захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна.

- Нээлттэй;
- Харьцуулалт;
- Гэрээ шууд байгуулах; болон
- Нэг эх үүсвэрээс худалдан авах.

Захиалагч гэрээ шууд байгуулах арга болон нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж, гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

Мөн, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын хувьд тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш, хэрэв гадаадын этгээд оролцох боломжтой бол ажлын 20-иос дээш өдөр байхаар заахаар тусгасан.

### Үнэлгээний шалгуур

Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх гурван үндсэн шалгуурыг хуульчилсан. Эдгээр нь 1) харьцуулах үнэ 2) ашиглалтын хугацааны өртөг 3) чанар ба үнийн хосолмол юм.



## Маргаан хянан шийдвэрлэх

### Маргаан хянан шийдвэрлэх

Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг илүү нарийвчлан зохицуулсан. Гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор гомдол гаргагчийн нэрийг дурдалгүйгээр гомдлын агуулгыг цахим системд нийтэлнэ. Мөн, гомдол шийдвэрлэх хугацааг илүү богиносгосон буюу гомдол шийдвэрлэж буй захиргааны байгууллагаасаа хамааран ажлын 3 – 10 хоног байхаар хуульчилсан байна.

*Хэрэв танд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан асуух зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.*

**Энд дарж тус хуультай танилцаарай.**



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН-ийг илэрхийлнэ.